



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 1/369

Өлгий

Согтууруулах ундаагаар худалдаа,  
үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, дэлгүүрийн  
ажиллах цагийн хуваарийг тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "ж", Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар худалдаа эрхэлдэг дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийг 09-22 цаг, үйлчилгээ эрхэлдэг уушийн газрын ажиллах цагийн хуваарийг 10-24 цаг хүртэл байхаар тогтоосугай.
2. Долоо хоногийн Баасан гараг бүрт согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ эрхлэхийг хориглосугай.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
4. Тус захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны "Цагийн хуваарь батлах тухай" 210 дугаар захирамж хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэ захирамж нь захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэгдэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд" нийтлэгдсэн өдрөөс хүчин төгөлдөр болно.

ЗАСАГ ДАРГА  А. ГЫЛЫМХАН



0101190816